



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/Ю

Есөнбулаг сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.4, 50.5 дахь хэсэг, Сангийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/100 дугаар тушаалаар батлагдсан "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар Бугат сумын 1.1 км цемент бетон хучилттай автозамын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Л.Хаш-Эрдэнэ (Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга)

Гишүүд: Н.Бадамгарав (Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)
Ж.Мөнхцэцэг (Хөндлөнгийн төлөөлөл)
(тохиролцсон)
Б.Доржпалам (Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл)
(тохиролцсон)

Нарийн бичиг Ч.Мэндбаяр (Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулан, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу шуурхай зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг үнэлгээний хороо (Л.Хаш-Эрдэнэ)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

